

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИЙН ЗАХИРАЛ
Т.ТҮДЭВДАГВА

2021.02.25 № 07/548
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори тайланг онд 9 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>256,802,843.26</u>	<u>335,652,322.26</u>
33	АВЛАГА	-	637,206.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	637,206.00
35	БАРАА МАТЕРИАЛ	256,802,843.26	335,015,116.26
351	Түүхий эд материал	43,077,568.25	42,903,389.25
35110	Тусгай зориулалттай материал	7,813,336.25	7,813,336.25
35130	Эм боох материал	35,264,232.00	35,090,053.00
354	Хангамжийн материал	213,725,275.01	292,111,727.01
35410	Бичиг хэргийн материал	1,200,000.00	2,708,050.00
35420	Аж ахуйн материал	19,472,539.00	36,107,572.00
35430	Сэлбэг хэрэгсэл	179,626,439.78	239,869,808.78
35470	Бусад хангамжийн материал	13,426,296.23	13,426,296.23
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,644,058,107.47</u>	<u>3,194,684,688.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,644,058,107.47	3,194,684,688.55
392	Биет хөрөнгө	1,486,561,467.47	3,037,016,159.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	739,462,417.00	797,854,191.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,727,851.60)	(50,206,358.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,700,000.00	22,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,200,000.00)	(22,700,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,139,245,000.66	5,472,312,810.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,367,732,762.29)	(3,198,666,654.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,289,980.80	46,326,266.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,475,317.10)	(30,604,094.82)
393	Биет бус хөрөнгө	157,496,640.00	157,668,529.40
39301	Программ хангамж	13,198,348.00	1,731,336.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,198,348.00)	(1,559,446.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	157,496,640.00	157,496,640.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,900,860,950.73</u>	<u>3,530,337,010.81</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>637,206.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	637,206.00
413	Өглөг	-	637,206.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	637,206.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,900,860,950.73</u>	<u>3,529,699,804.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,900,860,950.73	3,529,699,804.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,900,860,950.73	3,529,699,804.81
51101	Өмч: - төрийн	3,760,586,825.51	3,760,586,825.51
512	Хуримтлагдсан үр дүн	(2,168,450,057.28)	(539,611,203.20)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,168,450,057.28)	(2,168,450,057.28)
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,628,838,854.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	308,724,182.50	308,724,182.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,900,860,950.73</u>	<u>3,530,337,010.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	623,437,401.00	2,498,651,453.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,693,290.00	1,825,736,816.76
120	Нийтлэг татварын бус орлого	79,693,290.00	1,825,736,816.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,693,290.00	1,825,736,816.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,299,900.00	35,100,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	50,393,390.00	1,790,636,516.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	543,744,111.00	672,914,637.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	506,401,800.00	610,873,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	506,401,800.00	610,873,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,725,800.00	59,607,978.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	403,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,725,800.00	59,204,778.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,616,511.00	2,433,659.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих /ХЧТАТ/	4,616,511.00	2,433,659.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	758,675,098.20	869,812,599.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	758,675,098.20	869,812,599.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	744,107,194.20	804,128,559.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,169,239.00	400,920,774.00
210101	Үндсэн цалин	275,944,480.00	271,486,424.00
210102	Нэмэгдэл	39,961,659.00	103,609,997.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,263,100.00	25,824,352.44
210104	Урамшуулал	-	-
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,216,042.00	52,876,500.00
210201	Тэтгэврийн даатгал	28,538,242.00	37,209,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,169,500.00	3,916,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,535,600.00	3,133,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	633,800.00	783,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,338,900.00	7,833,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,533,329.00	31,404,161.00
210301	Гэрэл, цахилгаан	19,060,549.00	21,860,530.00
210302	Түлш, халаалт	8,908,480.00	7,840,471.00
210303	Цэвэр, бохир ус	1,564,300.00	1,703,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,091,659.00	11,948,985.00
210401	Бичиг хэрэг	2,844,147.00	848,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,465,000.00	5,051,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,514,494.00	1,692,929.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	405,000.00	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,863,018.00	4,036,556.00
2105	Нормативт зардал	9,151,236.00	37,132,819.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,511,236.00	33,688,319.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	640,000.00	3,444,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,939,829.00	9,098,357.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	76,216,887.00	5,556,799.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,589,042.00	1,387,940.00
210604	Урсгал засвар	5,133,900.00	2,153,618.00
2107	Томилолт, зочны зардал	4,606,900.00	3,123,640.00
210702	Дотоод албан томилолт	4,606,900.00	3,123,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,617,814.00	20,409,938.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,296,620.00	15,680,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,296,700.00	1,689,280.00
210803	Даатгалын үйлчилгээ	185,760.00	186,980.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,345.00	130,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-
210807	Газрын төлбөр	2,669,389.00	2,668,148.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	214,781,146.20	237,213,385.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,340,000.00	2,315,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,305,000.00	4,956.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	208,136,146.20	234,893,329.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,567,904.00	65,684,040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,546,511.00	55,313,727.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,616,511.00	2,433,659.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,930,000.00	300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	49,580,068.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,021,393.00	10,370,313.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,021,393.00	10,370,313.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(135,237,697.20)	1,628,838,854.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	65,968,849.28	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	65,968,849.28	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(65,968,849.28)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(201,206,546.48)	1,628,838,854.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	573,044,011.00	708,014,937.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,299,900.00	35,100,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,299,900.00	35,100,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,299,900.00	35,100,300.00
1.00E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,299,900.00	35,100,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	543,744,111.00	672,914,637.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	506,401,800.00	610,873,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	506,401,800.00	610,873,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,725,800.00	59,607,978.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	403,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,725,800.00	59,204,778.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,616,511.00	2,433,659.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,616,511.00	2,433,659.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	572,136,111.00	700,938,647.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	572,136,111.00	700,938,647.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	557,568,207.00	635,254,607.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,099,676.00	400,920,774.00
210101	Үндсэн цалин	275,792,600.00	271,486,424.00
210102	Нэмэгдэл	40,043,976.00	103,609,997.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,263,100.00	25,824,352.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,285,605.00	52,876,500.00
210201	Тэтгэврийн даатгал	28,607,805.00	37,209,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,169,500.00	3,916,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,535,600.00	3,133,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	633,800.00	783,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,338,900.00	7,833,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,533,329.00	31,404,161.00
210301	Гэрэл, цахилгаан	19,060,549.00	21,860,530.00
210302	Түлш, халаалт	8,908,480.00	7,840,471.00
210303	Цэвэр, бохир ус	1,564,300.00	1,703,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,654,687.00	17,116,551.00
210401	Бичиг хэрэг	2,875,200.00	1,706,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,465,000.00	5,051,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,514,494.00	1,692,929.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	405,000.00	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,394,993.00	8,346,122.00
2105	Нормативт зардал	11,069,520.00	46,304,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,979,520.00	40,395,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,090,000.00	5,909,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	102,920,676.00	60,783,743.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	93,318,846.00	50,023,403.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,029,950.00	4,777,340.00

210604	Урсгал засвар	5,571,880.00	5,983,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,606,900.00	3,123,640.00
210702	Дотоод албан томилолт	4,606,900.00	3,123,640.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,617,814.00	20,409,938.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,296,620.00	15,680,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,296,700.00	1,689,280.00
210803	Даатгалын үйлчилгээ	185,760.00	186,980.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,345.00	130,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-
210807	Газрын төлбөр	2,669,389.00	2,668,148.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,780,000.00	2,315,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,340,000.00	2,315,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,440,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,567,904.00	65,684,040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,546,511.00	55,313,727.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,616,511.00	2,433,659.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,930,000.00	300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	49,580,068.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,021,393.00	10,370,313.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,021,393.00	10,370,313.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>907,900.00</u>	<u>7,076,290.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	907,900.00	7,076,290.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	907,900.00	7,076,290.00
2200	Дотоод эх үүсвэрээр	907,900.00	7,076,290.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	907,900.00	7,076,290.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(907,900.00)</u>	<u>(7,076,290.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,760,586,825.51	308,724,182.50	-2,168,450,057.28	1,900,860,950.73
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,760,586,825.51	308,724,182.50	-2,168,450,057.28	1,900,860,950.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,760,586,825.51	308,724,182.50	-2,168,450,057.28	1,900,860,950.73
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	1,628,838,854.08	1,628,838,854.08
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,760,586,825.51	308,724,182.50	-539,611,203.20	3,529,699,804.81

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	636,810,500.00	636,278,909.00	(531,591.00)	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	636,810,500.00	636,278,909.00	(531,591.00)	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,230,400.00	586,698,841.00	(531,559.00)	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	391,677,900.00	391,557,980.00	(119,920.00)	100.0
210101	Үндсэн цалин	271,567,500.00	271,486,424.00	(81,076.00)	100.0
210102	Нэмэгдэл	94,247,300.00	94,247,203.56	(96.44)	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,863,100.00	25,824,352.44	(38,747.56)	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,876,500.00	52,876,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	37,209,400.00	37,209,400.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,916,700.00	3,916,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,133,500.00	3,133,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	783,300.00	783,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,833,600.00	7,833,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,734,800.00	31,404,161.00	(330,639.00)	99.0
210301	Гэрэл, цахилгаан	21,860,600.00	21,860,530.00	(70.00)	100.0
210302	Түлш, халаалт	8,069,900.00	7,840,471.00	(229,429.00)	97.2
210303	Цэвэр, бохир ус	1,804,300.00	1,703,160.00	(101,140.00)	94.4
2104	Хангамж, бараа материалын зардал	11,666,000.00	11,611,829.00	(54,171.00)	99.5
210401	Бичиг хэрэг	1,706,700.00	1,706,500.00	(200.00)	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,051,500.00	5,051,000.00	(500.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,693,000.00	1,692,929.00	(71.00)	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	370,500.00	320,000.00	(50,500.00)	86.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,844,300.00	2,841,400.00	(2,900.00)	99.9
2105	Нормативт зардал	38,809,200.00	38,804,200.00	(5,000.00)	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,400,000.00	35,395,200.00	(4,800.00)	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,409,200.00	3,409,000.00	(200.00)	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,971,400.00	44,967,343.00	(4,057.00)	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	41,700,500.00	41,700,003.00	(497.00)	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,278,500.00	2,277,340.00	(1,160.00)	99.9
210604	Урсгал засвар	992,400.00	990,000.00	(2,400.00)	99.8
2107	Томилолт, зочны зардал	2,730,000.00	2,720,440.00	(9,560.00)	99.6
210702	Дотоод албан томилолт	2,730,000.00	2,720,440.00	(9,560.00)	99.6

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,449,500.00	10,441,288.00	(8,212.00)	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,711,500.00	5,711,500.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,689,300.00	1,689,280.00	(20.00)	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	187,000.00	186,980.00	(20.00)	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,900.00	130,380.00	(520.00)	99.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,300.00	55,000.00	(300.00)	99.5
210807	Газрын төлбөр	2,675,500.00	2,668,148.00	(7,352.00)	99.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,315,100.00	2,315,100.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,315,100.00	2,315,100.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,580,100.00	49,580,068.00	(32.00)	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,580,100.00	49,580,068.00	(32.00)	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,580,100.00	49,580,068.00	(32.00)	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	636,810,500.00	636,278,909.00	(531,591.00)	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	610,873,000.00	601,178,609.00	(9,694,391.00)	98.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	610,873,000.00	601,178,609.00	(9,694,391.00)	98.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,937,500.00	35,100,300.00	9,162,800.00	135.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,937,500.00	35,100,300.00	9,162,800.00	135.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36	36	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	28	28	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	7	7	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		59,607,978.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		59,607,978.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		55,632,056.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		9,362,794.00
210102	Нэмэгдэл		9,362,794.00
	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл		-
2104	Хангамж, бараа материалын зардал		5,904,722.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,904,722.00
2105	Нормативт зардал		7,500,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		5,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		22,492,690.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		14,999,690.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,500,000.00
210604	Урсгал засвар		4,993,000.00
2107	Томилолт, зочны зардал		403,200.00
210702	Дотоод албан томилолт		403,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		9,968,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		9,968,650.00
	Бараа үйлчилгээний бусад зардал		-
	Бараа үйлчилгээний бусад зардал		-
	төвлөрүүлэх шилжүүлэг		-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,975,922.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		3,975,922.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,000,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		675,922.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		59,607,978.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		59,607,978.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Т.Түдэвдагва танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийн хуваарийг баталгаажуулан авч мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Шилэн баланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Өлзийхишиг, аудитор Б.Отгон-Өлзий, Ц.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Шилэн баланс Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/67 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байн

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол орны цаг агаарын хяналт, шинжилгээ, хэмжил зүйн баталгаажуулалт хийх;
- Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд цалин хөлсний нэмэгдэл, шатлалын Засгийн газрын 2020 оны 151, 184 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль, орчин аялал жуулчлалын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь 2020 онд Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй боловч дотоод хяналт нь үр нөлөөтэй гэж үнэлэв.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 869,812.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17,396.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,629,476.0 мянган төгрөгөөр буюу 85.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		637.2	(637.2)
Урьдчилгаа			-
Бараа материал	256,802.8	335,015.0	(78,212.2)
Үндсэн хөрөнгө	1,644,058.1	3,194,684.7	(1,550,626.6)
Нийт хөрөнгө	1,900,860.9	3,529,699.7	(1,628,838.8)
Өр төлбөр		637.2	(637.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,900,861.0	3,529,699.8	(1,628,838.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,900,861.0	3,530,337.0	(1,629,476.0)

Авлага дансны үлдэгдэл 637.2 мянган төгрөг болсон нь 2020 оны 12 сард нэр, данс зөрүүтэй гүйлгээ буцаж орж ирсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 335,015.0. мянган төгрөг болж 78,212.8 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн сайдын 2020 оны 222 дугаар тушаалаар буцаан олгосон давсан орлогоор лабораторийн шинжилгээний гол нэрийн материал нөөцлөн бэлтгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд шаардлага хангахгүй, ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,194,684.7 мянган төгрөг болж 1,629,476.0 мянган төгрөгөөр өссөн нь барилга, байгууламж 58,391.8 мянган төгрөгөөр, машин, тоног төхөөрөмж 1,719,879.9 мянган төгрөгөөр, тавилга, эд хогшил 7,076.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны А-1/2358 дугаарын албан бичгээр олгосон зөвшөөрлөөр ЦУОШГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 1,472,851.5 мянган төгрөгийн, БОАЖЯ-ны Агаарын бохирдол бууруулах үндэсний хорооноос шилжүүлсэн 306,451.6 мянган төгрөгийн, урсгал төсвийн худалдан авалтаар бэлтгэсэн 7,076.3 мянган төгрөгийн барилга, машин, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 329 дүгээр тогтоолоор 386,852.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 40.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тус газрын 2020 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1/135 дугаар албан бичгийн дагуу 12,498.3 мянган төгрөгийн программ хангамжийг тус тус акталж данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 637.2 мянган төгрөг болсон нь 2020 оны эцэст нэр зөрүүтэй гүйлгээ буцаан орж ирсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,529,699.8 мянган төгрөг болж 1,628,828.8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Лабораторийн гол нэр төрлийн багаж төхөөрөмжийг хөрөнгө оруулалтаар бэлтгэн шинэчилснээр тайлант оны өөрийн орлогын төлөвлөгөө 35.2 хувь буюу 9,162.8 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,875,2114.1 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.

Энэ нь үндсэн хөрөнгийн өсөлттэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 100,577.2 мянган төгрөгөөр буюу 0.02 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардлууд байна. Энэ нь Агаарын чанарын харуулын байр ашиглалтад орсонтой холбоотой дээрх зардлууд нэмэгдсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 557,283.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс цалин хөлсний зардлыг 102,188.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 18,137.9 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардал, тэтгэврийн тэтгэмжийг 21,918.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсийг 1,279.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, тогтмол зардлыг 2,633.4 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардлыг 6,326.6 мянган төгрөгөөр, норматив зардлыг 3,570.7 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардлыг 17,727.1 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 6,470.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг 13,837.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт дүнгээр 89,871.4 мянган төгрөгөөр нэмж 651,966.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийн хуваарьт 2020 оны 9 дүгээр сард өөрчлөлт оруулж 637,229.5 мянган төгрөг болгон бууруулсан байна. Энэ нь орлогын төлөвлөгөө тасарч байсантай холбоотой өөрчилсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 636,810.5 мянган төгрөгийн төсөв баталснаас /хөтөлбөр дотор төсвийн хуваарьт өөрчлөлт орсон/ 610,873.0 мянган төгрөгийг улсын төсвөөс 25,937.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 610,810.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 35.100.0 мянган төгрөг, нийт 645,910.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 636,278.9 мянган төгрөгийг зарцуулж 9,631.6 мянган төгрөгийн давсан орлогыг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 636,278.9 мянган төгрөг буюу 99.92 хувьтай байгаа нь цалин, хөлсний зардлыг 119.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол

зардлыг 330.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 54.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Цалин хөлс, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардлын хэмнэлт нь шинээр ашиглалтад орсон байрны зардлаас хэмнэгдсэн,

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өмнөх оны давсан орлогын хүрээнд бий болсон 59,608.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсний зардалд 9,396.8. мянга, хангамж, бараа материалын зардалд 5,901.7 мянга, норматив зардалд 7,500.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 22,492.7 мянга, томилолтын зардалд 403.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд 9,968.7 мянга, урсгал шилжүүлэгт 3,300.0 мянган төгрөг нийт 58,932.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 675.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 15 мэдээлэл, 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн судалгаагаар Сангийн яамны 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн гэрээт ажлын хөлсний үлдэгдэл 6,042.4 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого, 2020 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн ахмад ажилтны тэтгэврийн тэтгэмжийн 20,896.0 мянган төгрөгийн санхүүжилт, тухайн тэтгэмжийг олгосон зарлагын гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн данснаас ажилчдыг гэрээгээр Агай хатан ХХК-д эрүүл мэндийн үзлэгт хамруулсан хөлс 8,761.0 мянган төгрөг нийт орлогын 2, зарлагын 2 ажил гүйлгээг шилэн дансны цахим мэдээлэлд мэдээлээгүй, тушаал шийдвэрийг оруулаагүй зөрчил илэрлээ.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 56,423.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 44.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлж, нэг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 44.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлэв.

Албан томилолтоор ажиллагсад засвартай хуудсаар, зам хоногийг илүү тооцож 44.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 -д Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар эсвэл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 15 мэдээлэл, 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг, гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” мэдээлэх заалт, Эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Тус төв нь 2014 онд баригдсан Цаг уур орчны шинжилгээний газрын ажилчдын орон сууцны газрын төлбөрийг жил бүр төсвөөс төлсөн байна. Нийслэлийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/100 тоот захирамжаар лабораторийн төвийн эрдэм шинжилгээний зориулалттай 2014 м.кв газрыг орон сууцны зориулалтаар ашиглуулахаар гэрчилгээ олгосон боловч Цаг уур орчны шинжилгээний газарт шилжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар гүйцээж шалгаагүй горим сорил болон анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Төсвийн хуваарилалттай холбоотой асуудал

- 1.1. ***Илрүүлэлт:*** Сангийн яамнаас жилийн төсвийн хуваарь болон төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан тухай бүр нь төсвийн хуваарийг баталгаажуулж авдаггүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.
- 1.2. ***Эрсдэл:*** Төсвийн хөрөнгийн эдийн засгийн ангиллыг хооронд нь зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулах буюу хяналт тавихад хүндрэл учруулах.
- 1.3. ***Өгсөн зөвлөмж:*** Төсвийн хуваарьт өөрчлөлт орсон тухай бүр нь батлагдсан хуваарийг авч, мөрдөж ажиллах.
- 1.4. ***Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*** Холбогдох гүйлгээг авлагад бүртгэж, цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021 он			САГ-2021/40/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Сангийн яамнаас жилийн төсвийн хуваарь болон төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан тухай бүр нь төсвийн хуваарийг баталгаажуулж авдаггүй.	-	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	Т.Түдэвдагва Ч.Цэцэгдэлгэр
2	Албан томилолтоор ажиллагсад засвартай хуудсаар, зам хоногийг илүү тооцож нөхөн олговор олгосон	44.0	Төлбөрийн акт	Захирал, Нягтлан бодогч	Т.Түдэвдагва Ч.Цэцэгдэлгэр
3	Шилэн дансны цахим хуудсанд 3 удаагийн ажил гүйлгээг байршуулаагүй	-	Албан шаардлага	Захирал, Нягтлан бодогч	Т.Түдэвдагва Ч.Цэцэгдэлгэр
4	Тус төв нь 2014 онд баригдсан Цаг уур орчны шинжилгээний газрын ажилчдын орон сууцны газрын төлбөрийг жил бүр төсвөөс төлсөн байна.	-	Албан шаардлага	Захирал, Нягтлан бодогч	Т.Түдэвдагва Ч.Цэцэгдэлгэр
ДҮН					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 149/А0170078

Улаанбаатар хот

С.ЯТ- 2021/110/СТА-ПчЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн эрдэм шинжилгээний зориулалттай 7133 м.кв /0.7133га/ газраас 2014 м.кв /0.2014га/ газарт Цаг уур орчны шинжилгээний газар /ЦУОШГ/-ын ажилчдын орон сууц 2014 онд баригдаж, газрын зориулалтад өөрчлөлт хийгдсэнийг Цаг уур орчны шинжилгээний газар /ЦУОШГ/-т шилжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын 8-д “Төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон газар эзэмших эрхийн зориулалтыг өөрчлөх, төрийн өмчит хуулийн этгээд хооронд хуваах, шилжүүлэн эзэмшүүлэх асуудлыг тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн хамт шийдвэрлэх саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасугай” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 000010759 дугаар бүхий гэрчилгээтэй 2014м.кв газрыг Цаг уур орчны шинжилгээний газар /ЦУОШГ/-т шилжүүлэх асуудлыг шийдвэрлэн, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал Т.Түдэвдагва, нягтлан бодогч Ч.Цэцэгдэлгэр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ШИЛЭН БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Б.ОТГОН-ӨЛЗИЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 39/А0170078

Улаанбаатар хот

САГ-2021/110/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нэр бүхий 2 ажилтанд албан томилолтын 44,000 (Дөчин дөрвөн мянган) төгрөгийн нөхөн олговрыг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "...батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 301 тушаалын 2-т "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам хоног, уналгын зардлын төсвийг тухай бүр баталсны үндсэн дээр олгох, шаардлагагүй тохиолдолд төрийн албан хаагчийн байрны зардал төсөвлөн олгохгүй байхыг төсөвт байгууллагын, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга нарт зөвлөсүгэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

Илүү олгосон албан томилолтын нөхөн олговрыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

- Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал Т.Түдэвдагва, нягтлан бодогч Ч.Цэцэгдэлгэр нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ШИЛЭН БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ЦЭРЭНХҮҮ

Б.ОТГОН-ӨЛЗИЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 148/АОТ0078

Улаанбаатар хот

СДТ-2021/40/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 148 мэдээллээс хугацаа хоцроосон 15 мэдээлэл, мөн 4 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т байгууллага дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг, гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал Т.Түдэвдагва, нягтлан бодогч Ч.Цэцэгдэлгэр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ЦЭРЭНХҮҮ

ШИЛЭН БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.ОТГОН-ӨЛЗИЙ

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.